



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэмандал сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/175/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цог-Эрдэнэ Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdeneg@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. Агуулга

1.Аудитын дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
4. Аудитын илрүүлэлт .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол улсын засгийн газар

## 1. АУДИТЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас/Факс: 976-70333141  
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.25 № 108  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЭРДЭНЭМАНДАЛ СУМЫН СОЁЛЫН  
ТӨВИЙН ДАРГА Б.ОТГОНСҮРЭН ТАНАА

#### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэмандал сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэмандал сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхгүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	15,907,638.59	15,663,666.73
2	АВЛАГА	1,972,954.59	1,841,382.73
3	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,972,954.59	1,841,382.73
4	БАРАА МАТЕРИАЛ	13,934,684	13,822,284
5	Хангамжийн материал	13,934,684	13,822,284
6	Аж ахуйн материал	12,929,184	12,816,784
7	Бусад хангамжийн материал	1,005,500	1,005,500
8	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	570,194,511.72	556,757,107.55
9	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	570,194,511.72	556,757,107.55
10	Биет хөрөнгө	566,078,511.72	552,641,107.55
11	Барилга, байгууламж, орон сууц	559,990,326.72	559,990,326.72
12	Хуримтлагдсан элэгдэл	-19,139,023.33	-31,078,225.09
13	Машин тоног төхөөрөмж(компьютер)	14,573,709.7	14,573,709.7
14	Хуримтлагдсан элэгдэл	-9,382,699.37	-10,880,901.78
15	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,792,827	5,792,827
16	Хуримтлагдсан элэгдэл	-5,792,827	-5,792,827
17	Ном	20,036,198	20,036,198
18	Биет бус хөрөнгө	4,116,000	4,116,000
19	Бусад биет бус хөрөнгө	4,116,000	4,116,000
20	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	586,102,150.31	572,420,774.28
21	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	586,102,150.31	572,420,774.28
22	Засгийн газрын хувь оролцоо	586,102,150.31	572,420,774.28
23	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	280,150,850.5	280,150,850.5
24	Хуримтлагдсан үр дүн	48,827,932.3	35,146,556.27
25	Өмнөх үеийн үр дүн	-92,265,129.14	48,827,932.3
26	Тайлант үеийн үр дүн	141,093,061.44	-13,681,376.03
27	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	257,123,367.51	257,123,367.51
28	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	586,102,150.31	572,420,774.28

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	245,256,810	82,723,400
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	147,823,510	
3	Нийтлэг татварын бус орлого	147,823,510	
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	147,823,510	
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	562,500	
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	147,261,010	
7	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	97,433,300	82,723,400
8	Улсын төвлөрсөн төсвөөс		82,723,400
9	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		82,723,400
10	Орон нутгийн төсвөөс санхүүжих	97,433,300	
11	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	97,433,300	
12	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	104,163,748.56	96,404,776.03
13	УРСГАЛ ЗАРДАЛ	104,163,748.56	96,404,776.03
14	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	78,642,548.56	95,702,876.03
15	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	53,651,700	59,420,400
16	Үндсэн цалин	46,920,400	46,549,056
17	Нэмэгдэл	6,731,300	12,871,344
18	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,270,045.41	8,153,271.86
19	Тэтгэврийн даатгал	3,123,945.41	5,776,471.86
20	Тэтгэмжийн даатгал	536,500	20,738
21	ҮОМШӨ-ний даатгал	429,200	1,048,862
22	Ажилгүйдлийн даатгал	107,400	118,800
23	Эрүүл мэндийн даатгал	1,073,000	1,188,400
24	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,160,000	11,260,000
25	Гэрэл, цахилгаан	1,700,000	1,800,000
26	Түлш, халаалт	6,360,000	9,360,000
27	Цэвэр, бохир ус	100,000	100,000
28	Хангамж, бараа материалын зардал	906,200	706,000
29	Бичиг хэрэг	66,600	66,500
30	Тээвэр, шатахуун	371,500	371,500
31	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	56,200	70,000
32	Ном, хэвлэл	85,600	66,300
33	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	326,300	131,700
34	Нормативт зардал	36,600	49,000
35	Нормын хувцас, зөөлөн эдлэл	36,600	49,000
36	Эд хогшил, урсгал засварын зардал		100,000
37	Урсгал засвар		100,000
38	Томилолт, зочны зардал	70,600	70,600
39	Дотоод албан томилолт	70,600	70,600
40	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,435,316	2,506,200
41	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,281,200	2,281,200
42	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000	80,000
43	Газрын төлбөр	74,116	145,000
44	Бараа үйлчилгээний бусад зардал	8,112,087.15	13,437,404.17
45	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,112,087.15	13,437,404.17
46	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,521,200	701,900
47	Бусад урсгал шилжүүлэг	25,521,200	701,900
48	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,521,200	701,900
49	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	141,093,061.44	13,681,376.03
50	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	141,093,061.44	13,681,376.03

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	280,150,850.5	257,123,367.51	-92,265,129.14	445,009,088.87
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	280,150,850.5	257,123,367.51	-92,265,129.14	445,009,088.87
3	Тайлант үеийн үр дүн			141,093,061.44	141,093,061.44
4	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	280,150,850.5	257,123,367.51	48,827,932.3	586,102,150.31
5	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	280,150,850.5	257,123,367.51	48,827,932.3	586,102,150.31
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	280,150,850.5	257,123,367.51	48,827,932.3	586,102,150.31
7	Тайлант үеийн үр дүн			-13,681,376.03	-13,681,376.03
8	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	280,150,850.5	257,123,367.51	35,146,556.27	572,420,774.28

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	97,995,800	82,723,400
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	562,500	82,723,400
3	Нийтлэг татварын бус орлого	562,500	
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	562,500	
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	562,500	
6	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		82,723,400
7	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого		82,723,400
8	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	97,433,300	
9	Орон нутгийн төсвөөс санхүүжих	97,433,300	
10	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	97,433,300	
11	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	97,995,800	82,723,400
12	УРСГАЛ ЗАРДАЛ	97,995,800	82,723,400
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	72,474,600	82,021,500
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	53,651,700	59,420,400
15	Үндсэн цалин	46,920,400	46,549,056
16	Нэмэгдэл	6,731,300	12,871,344
17	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,243,000	8,021,700
18	Тэтгэврийн даатгал	5,096,900	5,644,900
19	Тэтгэмжийн даатгал	536,500	20,738
20	ҮОМШӨ-ний даатгал	429,200	1,048,862
21	Ажилгүйдлийн даатгал	107,400	118,800
22	Эрүүл мэндийн даатгал	1,073,000	1,188,400
23	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,160,000	11,160,000
24	Гэрэл, цахилгаан	1,700,000	1,700,000
25	Түлш, халаалт	6,360,000	9,360,000
26	Цэвэр, бохир ус	100,000	100,000
27	Хангамж, бараа материалын зардал	693,600	693,600
28	Бичиг хэрэг	66,500	66,500
29	Тээвэр, шатахуун	371,500	371,500
30	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000	70,000
31	Ном, хэвлэл	66,300	66,300
32	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	119,300	119,300
33	Нормативт зардал	49,000	49,000
34	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,000	49,000
35	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000	100,000
36	Урсгал засвар	100,000	100,000
37	Томилолт, зочны зардал	70,600	70,600
38	Дотоод албан томилолт	70,600	70,600
39	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,506,700	2,506,200
40	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,281,200	2,281,200
41	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000	80,000
42	Газрын төлбөр	145,500	145,000
43	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,521,200	701,900
44	Бусад урсгал шилжүүлэг	25,521,200	701,900
45	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,658,700	
46	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,862,500	701,900
47	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		
48	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	82,723,400.0	82,723,400.0	-	100.0
2	УРСГАЛ ЗАРДАЛ	82,723,400.0	82,723,400.0	-	100.0
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,021,500.0	82,021,500.0	-	100.0
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	59,420,400.0	59,420,400.0	-	100.0
5	Үндсэн цалин	59,420,400.0	46,549,056.0	12,871,344.0	127.7
6	Нэмэгдэл		12,871,344.0	(12,871,344.0)	-
7	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,021,700.0	8,021,700.0	-	100.0
8	Тэтгэврийн даатгал	5,644,900.0	5,644,900.0	-	100.0
9	Тэтгэмжийн даатгал	594,200.0	20,738.0	573,462.0	2,865.3
10	ҮОМШӨ-ний даатгал	475,400.0	1,048,862.0	(573,462.0)	45.3
11	Ажилгүйдлийн даатгал	118,800.0	118,800.0	-	100.0
12	Эрүүл мэндийн даатгал	1,188,400.0	1,188,400.0	-	100.0
13	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,160,000.0	11,160,000.0	-	100.0
14	Гэрэл, цахилгаан	1,700,000.0	1,700,000.0	-	100.0
15	Түлш, халаалт	9,360,000.0	9,360,000.0	-	100.0
16	Цэвэр, бохир ус	100,000.0	100,000.0	-	100.0
17	Хангамж, бараа материалын зардал	693,600.0	693,600.0	-	100.0
18	Бичиг хэрэг	66,500.0	66,500.0	-	100.0
19	Тээвэр, шатахуун	371,500.0	371,500.0	-	100.0
20	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.0	70,000.0	-	100.0
21	Ном, хэвлэл	66,300.0	66,300.0	-	100.0
22	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	119,300.0	119,300.0	-	100.0
23	Нормативт зардал	49,000.0	49,000.0	-	100.0
24	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,000.0	49,000.0	-	100.0
25	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.0	100,000.0	-	100.0
26	Урсгал засвар	100,000.0	100,000.0	-	100.0
27	Томилот, зочны зардал	70,600.0	70,600.0	-	100.0
28	Дотоод албан томилот	70,600.0	70,600.0	-	100.0
29	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,506,200.0	2,506,200.0	-	100.0
30	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,281,200.0	2,281,200.0	-	100.0
31	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.0	80,000.0	-	100.0

Эрдэнэмандал сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

32	Газрын төлбөр	145,000.0	145,000.0	-	100.0
33	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	701,900.0	701,900.0	-	100.0
34	Бусад урсгал шилжүүлэг	701,900.0	701,900.0	-	100.0
35	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	701,900.0	701,900.0	-	100.0
36	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	82,723,400.0		82,723,400.0	
37	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			-	
38	Улсын төсвөөс санхүүжих			-	
39	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	82,723,400.0		82,723,400.0	
40	Орон нутгийн төсвөөс	82,723,400.0		82,723,400.0	
41	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
42	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
43	АЖИЛЛАГСАДЫН ТОО	7	7	-	100.0
44	Удирдах ажилтан	1	1	-	100.0
45	Гүйцэтгэх ажилтан	3	3	-	100.0
46	Үйлчлэх ажилтан	3	3	-	100.0
47	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	7	7	-	100.0
48	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	4	4	-	100.0
49	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3	3	-	100.0

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрдэнэмандал сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цог-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэмандал сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18 -ны өдрийн 2 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрдэнэмандал сумын Соёлын төв нь ард иргэдэд соёл урлаг, олон нийтийн арга хэмжээг зөв боловсон хүргэж, хүүхэд залуучуудын авъяас билгийг нээн илрүүлж, олныг хүртээл болгох мөн соёлын үйлчилгээний цар хүрээг өргөтгөж соёлын стандартын шаардлагыг хангах зорилготой соёл урлагын үйл ажиллагаа явуулдаг, орон нутгийн төсвөөс санхүүждэг, төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *“Соёл урлагийн хүртээмжтэй олон талт үйлчилгээг нийгэмд хүргэж чадахуйц өрсөлдөх чадвар бүхий, тогтвортой, харууцлагатай, үр ашигтай орон нутгийн онцлог шинжийг харуулсан соёл урлагийн үйлчилгээг хүргэх”* гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Соёлын тухай хуулийг 2021 оны 7 дугаар сарын 02-ний өдөр шинэчлэн найруулсан байна. Харин санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын нэгж нь байгууллагын болон санхүү төсвийн үйл ажиллагаатай холбоотойгоор чиглэлээр хяналт шалгалт хийхээр төлөвлөгөө

боловсруулан хэрэгжүүлж үр дүнг тооцож ажилласан байгаа нь дотоод хяналт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Эрдэнэмандал сумын Соёлын төв нь Архангай аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/841 дүгээр тушаалаар батлагдсан Соёлын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэмандал сумын Соёлын төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 82.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 0.57 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 13.7 сая төгрөгөөр буюу 2.3 хувиар буурсан нь материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

				/сая төгрөгөөр/	
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь	

Авлага	1.97	1.84	(0.13)	(6.64)
Бараа материал	13.93	13.82	(0.11)	(0.80)
Үндсэн хөрөнгө	570.19	556.76	(13.44)	(2.36)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>586.10</b>	<b>572.42</b>	<b>(13.68)</b>	<b>(2.33)</b>
Өр төлбөр	-	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	586.10	572.42	(13.68)	(2.33)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>586.1</b>	<b>572.4</b>	<b>(13.7)</b>	<b>(2.3)</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын үлдэгдэл 6.6 хувиар буурсан байна.

Авлагын данс нь 1.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд 1.9 сая төгрөгийн авлагыг барагдуулсан ч НДШ-ийн зөрүүгээр тайлант онд 1.8 сая төгрөгийн авлага үүсч үлдэгдлээр тусгасан байна.

- Бараа материалын үлдэгдэл 0.8 хувиар буурсан байна.

Бараа материалын данс нь 13.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 3.0 сая төгрөг нэмэгдэж, тайлант онд 3.1 сая төгрөгийн зарцуулалт гарч, 13.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 2.3 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 570.2 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй, тайлант онд үндсэн хөрөнгөнд өөрчлөлт ороогүй, тайлант хугацаанд байгуулсан 13.4 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 572.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 13.7 сая төгрөгөөр буурсантай холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	97.43	82.72	(14.71)
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.41		(0.41)
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	147.26		(147.26)
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.56	-	(0.56)
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>245.66</b>	<b>82.72</b>	<b>(162.94)</b>
Цалин, шимтгэлийн зардал	58.92	67.57	8.65
Бусад бараа үйлчилгээний зардал	20.13	28.13	8.00
Урсгал шилжүүлэг	25.52	0.70	(24.82)
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>104.57</b>	<b>96.41</b>	<b>(8.16)</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>141.10</b>	<b>(13.68)</b>	<b>(154.78)</b>

Эрдэнэмандал сумын Соёлын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт өмнөх оны мөн үеэс 14.7 сая төгрөгөөр буурсан нь албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж урамшуулал буурсантай холбоотой байна

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 105.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 60.4 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 82.7 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 82.7 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого төвлөрөөгүй, зарцуулалт гараагүй байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тус Соёлын төв нь 2021 онд шинээр батлагдсан Ковид-19 цар тахлын үед улс, аймаг сумын онцгой комиссоос аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгааны дагуу соёл урлагийн үйлчилгээг хориглосны улмаас соёл урлагийн болон олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулаагүй байна.

Мөн тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Соёлын тухай хуулийг 2021 оны 7 дугаар сарын 02-ний өдөр шинэчлэн найруулга батлагдаж 2022 оноос дагаж мөрдөж байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 92 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 82.7 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 10 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Албан томилолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
- Монгол улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын

дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 10 хувь буюу 0.4 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэл байхгүй тул судалгааг гаргаж ирүүлээгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрдэнэмандал сумын Соёлын төв нь 2021 онд 129 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 81 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж, 48 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: *Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаарлага өгөө.*

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Тухайн тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1.Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 10% буюу 0.4 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж хүргүүлээгүй байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

#### **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар 15.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 1 заалт бүхий зөвлөмж өглөө.

##### **4.1 Зөвлөмж**

###### **1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 33 нэр төрлийн 15.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй байна.

###### **Өгсөн зөвлөмж:**

Тухайн хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж одоо ашиглаж байгаа болон цаашид ашиглагдах хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэн Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “НББ-ийн дансны заавар”-ын 4.39-т заасны дагуу бүртгэл тайланд тусгах, харин ашиглалтын хугацаа дууссан, ашиглагдахгүй болсон хөрөнгийг ТБОНӨТХуулийн 31 дэхь заалтын дагуу арга хэмжээ авч ажиллах

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
			Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал												
1	Эрдэнэмандал сумын СТөв	Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 33 нэр төрлийн 15.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй	1	15.1							1	15.1
Дүн			1	15.1							1	15.1
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал												
1	Эрдэнэмандал сумын СТөв	МУЗГ-ын 43 дугаар тогтоолын хэрэгжилт 10 % буюу 0.4 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна	1	0.4					1	0.4		
2		48 мэдээлэл хугацаа хоцроосон.	1						1			
Дүн			2					2	0.4			
Нийт дүн			3	15.5					2	0.4	1	15.1